**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 25 өдөр          Дугаар А/438          Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Жи эс эхлэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн I, II дугаар 12 айлын орон сууцны барилгын гадна фасадны засваруудын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ц.Цогтбаяр | - Жаргалант сумын Засаг дарга |
| Гишүүд: | Д.Эрдэнэбат | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| | З.Өмиртай | - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга |
| | Б.Бурмаа | - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн |
| | С.Батдорж | - Аймгийн Архивын тасгийн дарга |
| | Н.Сугар | - “Жи эс эхлэл” ХХК-ийн захирал |
| | М.Отгонбаатар | - Иргэний төлөөлөл |
| | И.Жавхлан | - Иргэний төлөөлөл |
| Нарийн бичгийн дарга: | Б.Жамбалдорж | - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн |

Zah A/438 Kh
02 2324

2. "Жи эс эхлэл" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Цогтбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН